# ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫЭРХ ЗҮЙН ҮНДЭС

*Т.Азжаргал*
*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн*
*Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хошууч*

***Товч агуулга:*** Цагдаагийн байгууллага нь хууль сахиулах, захиргааны, цэргийн аль байгууллага байхаас үл хамааран Үндсэн хуулиар тодорхойлсон чиг үүрэг хэвээр хадгалагдана. Эрх зүйн шинэтгэлийн үр нөлөө нь энэ байгууллага ямар байгууллага байхад биш харин Цагдаагийн байгууллагад алба хааж байгаа цагдаагийн алба хаагчийн эрх, түүний баталгааг бүрдүүлэх нь байгууллагын чадавхитай холбоотой юм. Учир нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чадавхыг цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах эрхийн баталгаагаар тодорхойлдогбөгөөд хөдөлмөрлөх үйл ажиллагааны хэрэгжилтээс ажлын үр дүн нь ихээхэн шалтгаалдаг байна. Ажлын үр дүнгээр иргэдийн гэмт хэрэг, гэмт халдлагаас хамгаалагдах, нийтийн хэв журам, эрх зүйн зөрчлөөс хамгаалагдах, олон нийтийн аюулгүй байдал хангагдах, тэдгээрийн улмаас зөрчигдсөн эрхээ сэргээлгэх нөхцөл боломж бүрдэнэ гэж ойлгоно. Тиймээс энэ байгууллагын алба хаагчийн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах эрх, үйл ажиллагааны чадавхи хоёр нь нэг зоосны хоёр тал юм гэдгийг зайлшгүй анхаарах шаардлага байна.

***Түлхүүр үгс:*** Цагдаагийн байгууллага, хууль сахиулах байгууллага, цагдаагийн алба хаагч хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх, цалин хөлс авах эрх, амрах эрх.

## Оршил

Монголчуудын төрийг дээдлэх уламжлалт үзэл хандлага марксист номлолын нөлөөгөөр эрх зүй, хууль хоёрыг адилтгах үзэл нь хууль тогтоох үйл ажиллагааг суурь стандартаас нь хөндийрүүлж төрийн хүсэл зориг мэтээр хандах, эрх зүйн соёл, сэтгэлгээний өнөөгийн онцлог нь эрх зүйт ёсны шинэ соёл, үндсэн хуульт ёсыг төлөвшүүлэхэд харгалзан үзэх үндэсний хүчин зүйл мөн.

Монгол улсад 1990 оны ардчилсан хувьсгалыг хуульчлан бэхжүүлсэн Үндсэн хуулийг 1992 онд баталж манай улсын зорилгын туйлыг эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан байгуулах явдал гэж тунхаглажээ. Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, нийгэм улс төрийн тогтолцоог ардчилж хувийн болон нийтийн өмчийн аливаа хэлбэрийн тэгш эрхийг баталгаажуулсан, зах зээлийн харилцааг хөгжүүлсэн, хүн төрөлхтөний хөгжлийн түгээмэл зүй тогтолд нийцсэн, нийгмийг байгуулах асуудал МУ-ын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгуур суурь нь юм.

МУ-д шинэ Үндсэн хуулиа баталсанаас хойш гучин жилийн хугацаанд уг хуульд нийцүүлэн нийгмийг жолоодон зохион байгуулах гол хүч төрийн байгууллагын зохион байгуулалт үйл ажиллагааг ардчилах, нийгмийн харилцааг зохицуулах үндсэн хэрэгсэл эрх зүйн шинэтгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх олон ажил хийсэн боловч өнөөдрийг хүртэл тухайн ажлын үр дүн, хэрэгжилтийг үнэлж дүгнэж тодорхойлолгүйгээр шинэтгэх ажил, өөрчлөх ажил үргэжилж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль[88]-ийг батлан энэ байгууллагын эрх зүйн үндэс, статус, алба хаагчийн эрх зүйн байдал зэргийг тодорхойлон баталж, уг хууль нь хорин жилийн хугацаанд үүргээ гүйцэтгэсэн юм.

Энэ хугацаанд 2002 оноос эрх зүйн шинэтгэлийн үр дүнд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжийг шинэчлэн баталсан бөгөөд үүнийг МУ-д хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн хоёр дахьдавалгаа гэж үзэж болох юм.

Эрх зүйн шинэтгэлийн гурав дахь давалгаа нь нийгмийн хөгжлийн олон үе шатуудад хууль зүйн салбар тэр дундаа хууль сахиулах үйл ажиллагаа эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй явж ирсэн гэж үзэж цагдаа, прокурор, шүүх эрх мэдлийн тогтолцоог төвлөрүүлэх замаар шийдвэр гаргах ажиллагааг хэрэгжүүлдэг, дээд шатны байгууллагаас доод шатандаа тушаасан хөшүүн систем салбар дотроо буй болгосон зэргийг судалгаагаар тогтоон[89] гэмт хэрэг илрүүлэх хойшлуулашгүй ажиллагаа, иргэний өмч хөрөнгийг битүүмжлэх, хураан авах, нэгжих, үзлэг хийх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах буюу нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх гүйцэтгэх ажил, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанууд“Хууль сахиулах үйл ажиллагаа” гэсэн ойлголтод багтана хэмээн үзэж Улсын Их Хурлаас 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийг баталж, улмаар 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд түүнтэй холбогдох Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг боловруулснаар эрх зүйн шинэтгэлийн гуравдахьдавалгаа эхлэв. Гэвч энэхүү давалгаа үргэлжилж 2015 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг шинэчлэн боловсруулж 2016-2017 онд хүчин төгөлдөр болж дагаж мөрдөгдөн хууль зүйн салбарт үүргээ гүйцэтгэх болсон.

### Нэг. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс, харьцуулалт

2012 оноос хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн явцад Цагдаагийн байгууллагыг хууль сахиулах байгууллага гэж үзэж тухайн байгууллагын бодлогыг УИХ-аас эрх зүйн үндсийг нь тогтоох замаар тодорхойлсон бөгөөд үүнд дэлхийн улс орнуудын практик туршлагыг судалж хууль сахиулах үйл ажиллагааны цараг тодорхойлсон. Энэ нь нилээн өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүнийг нийт иргэдэд шууд мэдрэгдэх, хууль сахиулах, аюулгүй байдлын хосолсон шинжтэй үйлчилгээг цагдаагийн байгууллага гүйцэтгэдэг гэж үзэж цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хоёрны нэг нь иргэнд үйлчилдэг захиргааны байгууллагын шинжтэй нөгөө хэсэг нь хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэдэг шинжтэй байгааг үндэслэн 2013 оны Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн байгууллагыг

[88]Цагдаагийн байгууллагын тухай хууль, УБ., 1993 он, №8

[89]Эрүүгийн эрх зүй дэхь судалгааны илтгэл, Франц улс, Страсбург хот 2009 он, 8 дахь тал, Щвецарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Иргэдийн Алъянс Төвийн орчуулга, ХЗҮХ-ээс 2009, 2009 онуудад явуулсан "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгааны дүнгээс, http://www.icac.nsw.gov.au/files/pdf/pub2_5q1 .pdf-ийг үзнэ үү

“Хууль сахиулах байгууллага” хэмээн тодорхойлжээ.[90] Үүнтэй холбоотой цагдаагийн алба хаагчдыг бэлтгэдэг сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулга, нэршил хүртэл өөрчлөгдөхөд хүрсэн. Тухайлбал, цагдаагийн алба хаагч эрх зүйч мэргэжилтэй байхуу, хууль сахиулагч хөтөлбөрөөр суралцах уу, аюулгүй байдал, цагдаагийн ажил хөтөлбөрөөр суралцах уу гэдэг бодлогын өөрчлөлтүүд орсон. Сургалтын хөтөлбөр түүний агуулга, хичээлүүдийн эзлэх хувь хэмжээ хамаарал нь тухайн салбарын боловсон хүчний бодлогод чухал байр суурийг эзэлдэг гэдгийг анхаарах шаардлагатай. Хууль сахиулагчийг эсвэл аюулгүй байдал, цагдаагийн ажилтан бэлтгэнэ гэж тухайн сургалтын хөтөлбөрөөс бодлого тодорхойлох чадварыг олгодог, шинжлэх ухааны суурь хичээлүүдийн цагийн багтаамжид өөрчлөлт оруулах нь төгссөн боловсон хүчний чанарт сөргөөр нөлөөлнө. Тухайлбал, төрийн бодлого хэрхэн үргэлжилсэн бэ гэхээр 2013 онд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдаж хэрэгжилтийн явцад 3 дугаар зүйлийн 3.1-т *“хуульчийн мэргэжпийн үйл ажиллагаа" гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж, шүүн таслах ажиллагаанд оролцох болон бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэхийг "* гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн *"... шударга ёс, ... тэгш байдал, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”,* Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн“ажил *мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... эрхтэй.* ...”,Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан "... *хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан ... иргэнийг бусад шүүхийн шүүгчээр люмилж болно.”* гэснийг тус тус зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэцээс шийдвэрлэсэн. Энэхүү хуралдцэцийн гишүүдээс Хууль сахиулахын их сургуулийг 2013 оноос өмнөтөгссөн төгсөгчид хуульчийн мэргэжлээр ажиллах боломжтой, түүнээс хойштөгссөн төгсөгч хууль сахиулагч буюу хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд хамаарахгүй тухай хүртэл дурдаж байлаа.[91]

Учир нь цагдаагийн байгууллагыг хууль сахиулах байгууллага болгох тодорхой тохиолдол кейс үүссэн гэж үзсэн. Тухайлбал,2008 оны 7 сарын 1-ний хэрэг явдлын дараагаар цагдаагийн удирдлагыг уг үйл явдлын улмаас хүний амь нас үрэгдсэн явдалд гэм буруутай эсэхийг шүүхээр шийдвэрлэх үед өмнө нь бид цэрэгжсэн байгууллага байсан учраас тушаалаар ажилладаггэсэн ойлголттой

[90] Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2013, ТМ №29, 3.1. 3.1.Цагдаагийн албань гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага мөн.

[91]Учир нь 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль дагаж мөрдөгдсөн бөгөөд түүнээс өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг тайлбарласан Улсын дээд шүүхийн 2006 оны 08 дугаар тогтоолд “хуульч мэргэжлээрээ ажилласан хугацаа гэдэгт” эрх зүйч мэргэжлээр хууль зүйн дунд болон дээд боловсрол эзэмшсэн хүн зайлшгүй ажиллавал зохих дараах ажил, албан тушаалд ажилласан хугацааг тооцно гээд үүнд “Бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч, нотариатч, арбитрч, тэдгээрийн туслах ажилтан, нарийн бичгийн дарга...” нарыг хамааруулахаар тайлбарласан байна. Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтуудыг тухайн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуульд заасанаас бусад тохиолдолд буцаан хэрэглэхгүй байх нь эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд нийцнэ гэж үзжээ.

байсан боловч яг шүүхээр хэрэг шийдвэрлэх явцад бид иргэнд үйлчилдэг байгууллага болохоор цэргийн гэмт хэргээр зүйлчлэхгүй хэмээн маргаж байв. [92]

Гэхдээ цагдаагийн байгууллага цэргийн байгууллага биш юм бол бас захиргааны байгууллага ч бас биш юм. Иймээс ямар байгууллага байх ёстой вэ гэдэг асуудал хөндөгдсөн. Иймд бид цэргийн болон иргэний байгууллагын дунд “Хууль сахиулах байгууллага” гэсэн шинэ статус байх ёстой гэж үзсэний үндсэн дээр, тийм шаардлагаар эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Учир нь цагдаагийн байгууллага нь хууль сахиулах үйл ажиллагааг явуулахдаа иргэнрүү хандсан зорилго илүү тодорхой харагдаж байдаг хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллага болохоос цэргийн байгууллага биш гэсэн гаргалгааг гаргаж иржээ. Тухайлбал, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэргийн талаарх өргөдөл гомдлыг шийдвэрлэх үедээ иргэнд үйлчилдэг байна. Гэмт хэрэгтэй тэмцэх илрүүлэх болон таслан зогсоох, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх таслан зогсоох хязгаарлах үед хууль сахиулах чиг үүргээ биелүүлдэг байгууллага байна.

Хууль сахиулах байгууллага гэж: хууль зүйн хариуцлагыг тогтоосон хуулиудыг зөрчсөн үйлдэл, түүнийг үйлдсэн хүнийг илрүүлэх таслан зогсоох шийтгэл хүлээлгэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн албадлагын шинжтэй үйл ажиллагаа явуулах тогтолцоог хэлэх [93] бөгөөд Цагдаагийн албаны тухай 2013 оны хуулиар цагдаагийн байгууллага хууль сахиулах байгууллага, түүний алба хаагчийг хууль сахиулагч гэж тодорхойлж эрх зүйн үндсийг бүрдүүлж, энэ байгууллагын цаашдын чиг хандлага ч мөн хууль сахиулах байгууллагын хүрээнд баримжаалсан байсан. Тухайлбал, цагдаагийн байгууллагыг иргэнд аюулгүй байдлын үйлчилгээг үзүүлдэг учраас цэргийн байгууллагаас ялгах шаарлагатай хэмээн үзэжхууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын иргэнд үйлчлэх үүргийг тодорхой хэмжээнд гаргаж эрх зүйн шинэтгэлийг хийсэн боловч Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжууд бүрэн батлагдаагүйгээс үйл ажиллагаанд нь хийдэл гарч, тодорхой бэрхшээл учирсан бөгөөд цэрэгжсэн байгууллага гэсэн ойлголтоос нь салгаж чадаагүй юм. Тухайлбал,2013 оны Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн алба хаагч албан тушаалын цол хэрэглэхээр хуульчилсан атал 2015 онд Засгийн газрын тогтоол шийдвэрээр хугацааны цол хэрэглэх асуудлыг шийдвэрлэсэн. Энэ нь хуульд зүйн шинжлэх ухаанд эрх зүйн хэм хэмжээний зөрчлийг бий болгосон юм.

Гэвч хууль үйлчлээд тодорхой хугацаа өнгөрөхөд хуулиар зохицуулагдаагүй харилцаа үүсч, хууль сахиулах зарим процедур тогтоосон хэм хэмжээ дутагдалтайн[94] улмаас эрх зүйн хийдэл гарч эхэлсэн бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, цагдаагийн албаны үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, цагдаагийн алба хаагчийг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, зөвхөн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор зайлшгүй тохиолдолд хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд хүний эрх, эрх

[92]Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл-II, УБ., 2013 он, 222 дахь тал

[93]Хууль зүйн англи хэлний толь Black’s Dictionary

[94]Тухайлбал, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг Цагдаагийн албаны тухай хуулийг дагалдаж гарах хуулиуд батлагдаагүй юм.

чөлөөнд халдах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 2017 онд Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн боловсруулж баталсан.

2017 оны Цагдаагийн албаны тухай хууль батлагдсанаас хойш нийт 4 удаа нэмэлт өөрчлөлт оржээ. 2019 оны 6 сарын 6-ны өдөр Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль шинэчлэгдсэн батлагдсантай холбогдуулан зарим нэр томъёоны өөрчлөлт, 2021 оны 12 сарын 17-нд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан зарим нэр томъёоны өөрчлөлт оржээ. 2021 оны 12 сарын 27-нд Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдуулан Цагдаагийн байгууллагын бодлого төлөвлөлтийн баримт бичиг түүнийг батлах хэрэгжүүлэхтэй холбоотой зарим өөрчлөлт оржээ. 2022 оны 4 сарын 22-ны өдөр бүх шатны Засаг дарга, иргэдийн төлөлөөгчийн хурал, иргэдийн нийтийн хуралтай холбоотой зарим үг, эрх хэмжээний асуудалд өөрчлөлт оржээ. Учир нь хууль тогтоох эрх мэдэл гэдэг нь төрийн бодлогыг тодорхойлж, нийгмийн харилцааг зохицуулахын тулд ард түмний өмнөөс хууль тогтоомжийн акт гаргаж, түүнийгээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа байдлыг хянан шалгаж дэмжих замаар улсыг хуулиар жолоодох үйл ажиллагааг бүхэлд нь хэлнэ. Иймээс хууль бол төрийн бодлогын хэмжүүр юм. Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлийн 11.2-т заасныг үндэслэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бодлогыг хуулиар тодорхойлжээ.[95]

Монгол Улсад хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн үр дүнд Цагдаагийн байгууллагыг хууль сахиулах байгууллага гэж 2013 оны Цагдаагийн албаны тухай хуулиар[96] тодорхойлж гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээг толорхойлсон бол 2017 оны Цагдаагийн албаны тухай хуулийн зохицуулалтаас харахад УИХ-аас хууль тогтоох замаар Цагдаагийн байгууллагын бодлогыгөрчлөн цагдаагийн байгууллага нь төрийн тусгай алба бөгөөд цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал баталгаагаар хангагдсан Монгол улсын Ерөнхийлөгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн [97] зарлигаар цол олгох журмыг хугацааны дагуу тодорхойлсон цэргийн байгууллага болгон тодорхойлжээ.

Үүний нэг хүчин зүйл нь 2017 онд шинэчлэн батлагдсан Дотоодын цэргийн тухай хууль[98]-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт *“...дотоодын цэрэг” гэж дотоодын цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг;* 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт "... *Цагдаагийн төв байгууллагын дарга нь дотоодын цэргийн командлагч байна”,* гэж зааснаар нотлогдож байгаа юм. Мөн тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт *"... Дотоодын цэргийн алба хаагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч. нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно”,* 8 дугаар зүйлийн 8.1.3-т "... *цагдаагийн байгууллагатай харилцан ажиллах удирдамж, төлөвлөгөөг* ***Дотоодын цэргийн командлагч*** *батлах"-аар* зохицуулсанаас харахад дотоодын цэрэг болон цагдаагийн байгууллагын чиг үүргийг ялган зааглаж зохицуулжээ. Гэсэн хэдий ч цагдаагийн

[95]Монгол улсын Үндсэн хууль, УБ., 1992 он, ТМ №1-ийн арван нэгдүгээр зүйлийн 2-дахь хэсэгт “...Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэг тхүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно” гэжээ.
[96]Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2013, ТМ №29
[97]Монгол улсын Үндсэн хууль, УБ., 1992 он, ТМ №1, 33.2-т Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна хэмээн тодорхойлжээ.
[98]Дотоодын цэргийн тухай хууль, УБ., 2017 он, ТМ №12

алба хаагч нь цэргийн алба хаагчийн нэгэн адил эрх зүйн байдал, баталгаагаар хангагдаж байгаа бөгөөд хуулийн үзэл баримтлалын хувьд цэргийн байгууллага болох эрх зүйн үндэс бүрдсэн болохыг харуулж байна.

Цагдаагийн байгууллагыг хууль сахиулах байгууллагаас цэргийн байгууллага руу шилжиж байгааг нотлох эрх зүйн өөрчлөлтүүдээс дурдвал:

Хүснэгт 1. Хуулийн харьцуулалт:

| № | Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2013, ТМ №29, | **Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2017 он, ТМ №8-ийн үзэл баримтлал** |
|---|---|---|
| **1.** | **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**<br>1.1.Энэ хуулийн зорилт нь ~~хууль сахиулж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүрэгтэй~~ Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтооход оршино. | **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**<br>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтооход оршино. |
| **2.** | **2 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хууль тогтоомж**<br>2.1.Цагдаагийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, ~~Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль~~, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | **2 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хууль тогтоомж**<br>2.1.Цагдаагийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, *Төрийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль,* энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоосбүрдэнэ. |
| **3.** | **3 дугаар зүйл.Цагдаагийн алба**<br>3.1.Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг ~~үүрэг бүхий хууль сахиулах байгууллага~~ мөн. | **4 дүгээр зүйл.Цагдаагийн алба**<br>4.1.Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг *үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба* мөн. |
| **4.** | 4.2.5.алба хаагч удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг, даалгаврыг хуульд заасны дагуу биелүүлэх, хууль бус үүрэг даалгаврыг биелүүлэхээс татгалзах. | 5.3.Цагдаагийн алба хаагч дээд шатны байгууллага, *албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж, үндэслэлээ тайлбарлах эрхтэй.* |
| **5.** | **7 дугаар зүйл.Цагдаагийн албаны туг, бэлгэ тэмдэг**<br>7.1.Цагдаагийн алба нь туг, бэлгэ тэмдэгтэй байна. Цагдаагийн албаны туг, бэлгэ тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг ~~хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн~~ батална. | **8 дугаар зүйл.Цагдаагийн албаны туг, бэлгэ тэмдэг**<br>8.1.Цагдаагийн алба нь туг, бэлгэ тэмдэгтэй байна.<br>8.2.Цагдаагийн албаны бэлэг тэмдэг, тугны загвар болон туг, бэлгэ тэмдгийг хэрэглэх журмыг *Монгол Улсын Ерөнхийлөгч батална.* |
| **6.** | **8 дугаар зүйл.Цагдаагийн тангараг**<br>8.1.Монгол Улсын иргэн цагдаагийн | **9 дүгээр зүйл.Цагдаагийн тангараг**<br>9.1.Монгол Улсын иргэн цагдаагийн албанд ороxдоо:<br>“Монгол Улсын иргэн би цагдаагийн |

| | | |
|---|---|---|
| | албанд ороходоо<br>“Монгол Улсын иргэн ... би цагдаагийн албанд орж ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуул~~ийг дээдлэн сахиж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт~~ чин шударгаар зүтгэхээ иргэдийнхээ өмнө батлан тангараглая.~~Би хууль сахиулах ажлын эрдэм ухаанд цуцалтгүй суралцаж, алба хаагчийн сахилга, ёс зүйг чанд сахиж, цагдаагийн байгууллагад ажиллах явцдаа олж мэдсэн мэдээлэл, тусгай мэдлэгийг бусдад задруулахгүй байхаа тангараглая.~~Би энэ тангаргаасаа няцваас хуулийн хариуцлага хүлээнэ.” гэж тангараг өргөнө. | албанд орж ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, *алба хаагчийн сахилга, ёс зүй, албаны нууцыг чанд сахин, чин шударгаар ажиллаж, шаардлага гарвал амь биеэ үл хайрлан зүтгэхээ* батлан тангараглая.Би энэ тангаргаасаа няцваас хуулийн хариуцлага хүлээнэ.” гэж тангараг өргөнө. |
| **7.** | **67 дугаар зүйл.Цагдаагийн албан тушаалд тавигдах шаардлага**<br>67.1.Цагдаагийн тангараг өргөж, цагдаагийн аль нэг байгууллагад томилогдон ажиллаж байгаа, цагдаагийн цолтой иргэнийг цагдаагийн алба хаагч гэнэ. | |
| **8.** | **33 дугаар зүйл.Цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг**<br>33.1.Цагдаагийн алба хаагч нь ~~Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд~~ заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ. | **69 дүгээр зүйл.Цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг**<br>69.1.Цагдаагийн алба хаагч нь *Төрийн албаны тухай хуульд* заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ. |
| **9.** | **34 дүгээр зүйл.Цагдаагийн ~~албан тушаалын~~ цол**<br>34.1.Цагдаагийн алба хаагчид ~~доор дурдсан албан тушаалын~~ цол олгоно: | **74 дүгээр зүйл.Цагдаагийн цол**<br>74.1.*Эрхэлж байгаа албан тушаал, алба хаасан хугацаа, ажлын үр дүнг харгалзан* цагдаагийн алба хаагчид дараахь цол олгоно: |
| **10.** | 34.1.1.дээд цол: тэргүүн комиссар, тэргүүн дэд комиссар, дэд комиссар, туслах комиссар; | |
| **11.** | 34.1.2.ахлах цол: цагдаагийн хурандаа, цагдаагийн дэд хурандаа, цагдаагийн хошууч; | 74.1.1.ахлах цол: цагдаагийн хурандаа, цагдаагийн дэд хурандаа, цагдаагийн хошууч; |
| **12.** | 34.1.3.дунд цол: цагдаагийн ахмад, цагдаагийн ахлах дэслэгч, цагдаагийн дэслэгч; | 74.1.2.дунд цол: цагдаагийн ахмад, цагдаагийн ахлах дэслэгч, цагдаагийн дэслэгч; |
| **13.** | 34.1.4.бага цол: цагдаагийн ахлах ахлагч, цагдаагийн ахлагч, цагдаагийн дэд ахлагч. | 74.1.3.бага цол: цагдаагийн ахлах ахлагч, цагдаагийн ахлагч, цагдаагийн дэд ахлагч. |
| **14.** | **75 дугаар зүйл.Цагдаагийн цол олгох болзол**<br>75.1.Цагдаагийн алба хаагчид цагдаагийн бага, дунд цол олгоход дараахь хугацааг баримтална:<br>75.1.1.цагдаагийн дэд ахлагчаас цагдаагийн ахлагч - 4 жил;<br>75.1.2.цагдаагийн ахлагчаас цагдаагийн ахлах ахлагч - 4 жил;<br>75.1.3.цагдаагийн дэслэгчээс цагдаагийн ахлах дэслэгч - 3 жил;<br>75.1.4.цагдаагийн ахлах дэслэгчээс цагдаагийн ахмад - 3 жил;<br>75.2.Цагдаагийн алба хаагчид цагдаагийн ахлах цол олгоход дараахь хугацааг баримтална: | |

| | | |
|---|---|---|
| | 75.2.1.цагдаагийн хошууч цол олгоход цагдаагийн ахмад цолыг 4, түүнээс дээш жил хэрэглэсэн;<br>75.2.2.цагдаагийн дэд хурандаа цол олгоход цагдаагийн хошууч цолыг 5, түүнээс дээш жил хэрэглэсэн;<br>75.2.3.цагдаагийн хурандаа цол олгоход цагдаагийн дэд хурандаа цолыг 6, түүнээс дээш жил хэрэглэсэн.<br>75.3.Цагдаагийн алба хаагч бэлтгэх үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын алба хаагчид цагдаагийн төв байгууллагын дарга энэ хуульд заасан хугацаа, шалгуурыг баримтлан цагдаагийн цол олгож болно.<br>75.4.Эрхэлж байгаа албан тушаал, ажлын үр дүнг харгалзан зэрэг дэв дээгүүр болон энэ хуулийн 75.1, 75.2-т заасан хугацаанаас өмнө цагдаагийн алба хаагчид цагдаагийн цол олгож болно.<br>75.6.Цагдаагийн цолыг алгасуулан олгохыг хориглоно. | |
| **15.** | 35.3.Цагдаагийн ~~албан тушаалын~~ цол олгох журмыг ~~хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн~~ батална. | 76.2.Цагдаагийн цол олгох, *бууруулах, хураан авах, сэргээх* журмыг *Монгол Улсын Ерөнхийлөгч* батална. |
| **16.** | **37 дугаар зүйл.Алба хаагч, ажилтны баталгаа**<br>37.1.Цагдаагийн алба хаагч, ажилтан нь ~~Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд~~ заасан ~~баталгаанаас гадна доор дурдсан~~ баталгаагаар хангагдана: | **84 дүгээр зүйл.Алба хаагчийн баталгаа**<br>84.1.Цагдаагийн алба хаагч нь *Төрийн албаны тухай хуульд* заасан баталгаагаар хангагдана. |
| **17.** | **Дотоодын цэргийн тухай хууль, УБ., 2017 он, ТМ №12** | |
| **18.** | **4 дүгээр зүйл. Нэр томьёоны тодорхойлолт:** 4.1.1.“дотоодын цэрэг” гэж дотоодын цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг; | |
| **19.** | **7 дугаар зүйл. Дотоодын цэргийн бүтэц, удирдлага:** 7.2.Цагдаагийн төв байгууллагын дарга нь дотоодын цэргийн командлагч байна. | |
| **20.** | 18.1.Дотоодын цэргийн алба хаагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно. | |

Гэвч Цагдаагийн байгууллагад хийгдсэн эрх зүйн шинэтгэлээс дүгнэвэл хууль тогтоогчоос хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд хуулиар дамжуулан энэ байгууллагын бодлогыг тодорхойлж байгаа боловч цагдаагийн байгууллагын эрх зүйн үндсийг үйл ажиллагааны чиглэлийг Монгол Улсын Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлийн1 дэх хэсэгт "... *Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”,* арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Төрөөс ... *хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна."* гэж заасан нь цагдаагийн байгууллагыг төрийн нэрийн өмнөөс Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэйтэмцэх эрх, үүргийг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны эрх зүйн үндсийг зааж өгсөн бөгөөд аль ч эрх зүйн шинэтгэлийн үед цагдаагийн байгууллагын энэ чиг үүрэг хэвээр хадгалагдаж ирсэн. **Тиймээс цагдаагийн байгууллага ямар байгууллага байхаас үл хамааран Үндсэн хуулиар тодорхойлсон дээрх чиг үүрэг хэвээр хадгалагдана.**

## Хоёр. Цагдаагийн байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чанар харилцан хамаарал

Эрх зүйн шинэтгэлийн үр нөлөө нь энэ байгууллага ямар байгууллага байхад биш харин Цагдаагийн байгууллагад алба хааж байгаа цагдаагийн алба хаагчийн эрх, түүний баталгааг бүрдүүлэхэд чиглэх ёстой юм.Учир нь ***Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чадавхыг цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, эрхийн баталгаагаар тодорхойлдог*** бөгөөд энэхүү эрхийн хэрэгжилтээс үйл ажиллагааных нь үр дүн ихээхэн шалтгаалдаг байна. Тухайлбал энэ байгууллагын алба хаагчийн хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбогдсон эрх, үйл ажиллагааны чадавхи хоёр нь нэг зоосны хоёр тал юм гэдгийг зайлшгүй анхаарах шаардлага байна.

Учир нь сүүлийн жилүүдэд цагдаагийн байгууллагаас алба хаагчид олноор гарах болсон бөгөөд энэ нь нэг талаас тухайн байгууллагын боловсон хүчний бодлогод асуудал байна, мөн алба хаагчийн эрх зүйн байдал, ажлын ачаалал, гүйцэтгэх үйл ажиллагааны үр дүн, үнэлгээтэй шууд холбоотой болохыг ХЭҮК-ийн 14 дэх илтгэл болон, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 141-р тогтоолоос харж болно. Энэ асуудал нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд доголдол үүсгэж, албаны үйл ажиллагааны залгамж холбоо, шинэ залуу алба хаагчдыг дадлагажуулах, сургах процесс тасарч, үйл ажиллагааны уялдаа холбоонд тодорхой сөрөг нөлөө үзүүлж байна. Мэдээж үүний цаана Цагдаагийн байгууллагын хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгт" их биш ч тодорхой доголдол бэрхшээл учирч байдаг.

Цагдаагийн байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалж, урьдчилан сэргийлж, хүний аюулгүй, амар тайван амьдрах баталгааг бүрдүүлэх чиг үүрэгтэй бөгөөд тус байгууллагад үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хөдөлмөрлөх үйл ажиллагаатай нь холбоотой эрх зөрчигдөх эрсдэл өндөртэй бүлэгт хамаардаг [100] тул 2015 онд ХЭҮК-оос тухайн байгууллагын үйл ажиллагаанд тодорхой судалгааг хийжээ. Үүнээс харахад цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чанар нь боловсон хүчний бодлоготой \нийгэм, эдийн засаг улс төрийн баталгаа, цалин хөлс, ажлын цаг, ачаалал зэрэгтэй\ шууд хамаарч байна.

Сүүлийн жилүүдэд цагдаагийн байгууллагыг *"хүний эрхийг зөрчигч"* гэж тооцох, хандах болсноор тэдний хууль ёсны шаардлагыг үл тоох, бие махбодод халдах, заналхийлэх үзэгдэл гарсаар байна. Сүүлийн жилүүдэд сошиол орчны нөлөө ч маш их байна.

***Хүний эрхийг хамгаалж байгаа цагдаагийн байгууллагын албан хаагчдын эрх дараах байдлаар зөрчигддөг байна. Үүнд:***

- Нэр төр, алдар хүнд, бие махбодод нь халдах, заналхийлэх;
- Хөдөлмөрлөх, ажил үүргээ гүйцэтгэхэд саад болох;

[99] Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2017, Төрийн мэдээлэл №06, 4.1 .Цагдаагийн албаны гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чигүүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

[100]ХЭҮК "МУ дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 14 дэх илтгэл" УБ.. 2015 он тайлан илтгэл

- Сэтгэл зүйн дарамт үзүүлэх;
- Үндэслэлгүйгээр эрх зүйн хариуцлага тооцох, тооцохоор заналхийлэх хэлбэртэй байна.

"Хүний эрхийг хамгаалагчийн эрхийн хэрэгжилт" судалгаанд хамрагдагсдын 50 хувь нь Монгол Улсад хүний эрх хамгаалагчийн" аюулгүй байдал хангалтгүй", 30 хувь нь "дунд зэрэг хангагдсан" гэж үнэлсэн бол 20 хувь нь "аюулгүй байдал хангагдсан" гэж хариулсан байна. Аюулгүй байдал хангалтгүй гэж хариулсан хүмүүс "эрх зүйн орчин бүрдээгүй", "доромжлол, гүтгэлэгт өртдөг", "аюулгүй байдал хангагдаагүй". "хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжгүй" гэсэн шалтгааныг дурджээ. Ярилцлагад оролцогчид хүний эрхийг хамгаалагчийн эрх зөрчигдөхөд дор дурдсан хүчин зүйл нөлөөлдөг гэж үзжээ. Үүнд:

> Хууль сахиулах байгууллагуудад улс төрийн нөлөөлөл бий болсон;
> Хэвлэл мэдээллийн байгууллагын хариуцлагагүй байдал;
> Төрөөс хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах бодлого, эрх зүйн зохицуулалт хангалтгүй;
> Хүний эрхийг хамгаалагчийн ажлын ачаалал их гэж дурдсан байна.

**Шигтгээ:**

Ярилцлага:

Хууль сахиулах байгууллагуудад улс төрийн нөлөөлөл орж, хэт улс төржүүлснээс ажилтнуудын эрх зөрчигдөж байна. Хуулийн шинэчлэл нэрийдлээр өөр хоорондоо зөрүүтэй, зөрчилтэй хууль батлан гаргаснаас хэн нь юу хийх нь тодорхойгүй болж, улс төрийн томилгоо хийсэн нь албан хаагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байна. Цагдаагийн байгууллага улс төржилтгүй үед хүчтэй байсан, одоо бол сүр хүчгүй байна.

(Цагдаагийн албан хаагчидтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Судалгаагаар хүний эрхийг хамгаалагчийн эрхийг хэн, хэрхэн зөрчиж байгааг тодруулахад улс төрчид, улс төрийн нам, бүлэглэл, эрх баригчид болон төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, хэргийн оролцогч, шүүхийн шийдвэрээр эрхээ хязгаарлуулсан этгээдийн гэр бүлийн зүгээс зөрчдөг гэсэн байна.[101]

Судалгааны баримтаас үзвэл Монгол Улсад хүний эрхийг хамгаалагчийн эрхийг зөрчих явдал нийтлэг бөгөөд олон талтай байдгаас тэдний эрх зөрчигдөж буй байдлыг нэгдсэн тоон үзүүлэлтээр гаргах боломжгүй байна.

Цагдаагийн алба хаагчийн ажлын ачааллыг зүй зохистой байлгах, ажлын чанарыг сайжруулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 153 дугаар тогтоолоор "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг нормативыг тогтоосон бөгөөд дурдвал:

> 4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч,
> Хэв журмын эргүүл нийслэлд 15 000 хүн ам тутамд хоёроос доошгүй,
> Аймгийн төвд 5 000 хүн ам тутамд нэгээс доошгүй,
> Эргүүлийн нэг чиглэлд хоёр албан хаагч үүрэг гүйцэтгэхээр заажээ.

[101]ХЭҮК "МУ дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 14 дэх илтгэл" УБ., 2015 он, 56 дахь тал

> 350 тээврийн хэрэгсэл тутамд 1-ээс доошгүй замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагч,

> 150 км тутамд 1-ээс доошгуй орон нутаг дахь замын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуух цагдаагийн хяналтын цэг,

> Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах шууд үүрэг бүхий алба хаагч нийт орон тооны 75-аас доошгүй хувийг эзэлнэ,

> Хөдөлгөөнт эргүүлд 15000 хүн ам тутамд 1-ээс доошгүй,

> Сум дахь цагдаагийн алба хаагчид 1-ээс доошгүй автомашин байхаар тус тус зохицуулжээ.

**Дүгнэвэл:** Улсын хэмжээнд орон тоог 2175 офицер, 1138 ахлагч, 104 энгийн ажилтан буюу нийт 3417 алба хаагчаар нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд, **нийслэлд нийт** 962 офицер, 346 ахлагч, 61 энгийн ажилтны орон тоо нэмэгдүүлэх, **орон нутагт нийт** 1213 офицер 792 ахлагч, 41 энгийн ажилтны орон тоо нэмэгдүүлэх тооцоо гарсан байна.

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтан өдөрт 8 цаг буюу 7 хоногт 40 цаг.сард 160 цаг, жилд 1760 цаг ажиллах ёстой.

> Гэтэл нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагч 7 хоногийн 6 өдөр буюу хамгийн багадаа сард 192 цаг, жилд 2112 цаг ажиллаж, нийт **352 цагийн илүү үүрэг гүйцэтгэж** ажиллаж байна. */Жич: Үүнд шуурхай цугларалт, албаны бэлэн байдал, хүчлэн хамгаалалт зэрэг онцлог цаг үеэр ажиллуулсныг тооцоогүй болно./*

> Замын цагдаагийн алба хаагч жилд дунджаар 2288 цаг ажиллаж, үүнээс **528 цагийн илүү үүрэг гүйцэтгэж** ажиллаж байна.

> Шөнийн ээлжинд ажилласан алба хаагч сард 188, жилд **2068 цагийн илүү үүрэг гүйцэтгэж** ажиллаж байна.

**Эрх зүйн үндэслэл** нь:Төрийн албаны тухай хуулийн 41.3 дахь хэсэгт *“Төрийн албан хаагчийнхөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна”* гэж заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд “Долоо *хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна." “Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна.”, “Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна”* гэж заасныг үндэслэвэл энэ зохицуулалт огт хангагддаггүй болох нь харагдаж байна.

“Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?” гэсэн асуултанд 5 хувь нь өдөрт 8 цаг хүртэл, 22 хувь нь 8-10 цаг, 33 хувь нь 10-12 цаг, 40 хувь нь 12 цагаас дээш ажилладаг гэсэн дүн гарсан байна.

Зураг 1. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын ажлын ачаалал




Цагдаагийн ерөнхий газраас нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг нэг загвараар баталсан бөгөөд үүнд илүү цагаар ажиллах шаардлага тусгасан нь Төрийн албаны тухай хууль зөрчиж байна гэж үзжээ.

Орон тоо цөөн учир нийтийн хэв журам хамгаалах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчид нь байнга өндөр ачаалалтай, илүү цагаар ажилладаг тул сургалт, соён гэгээрүүлэх ажилд хамрагдаж чаддаггүй. Мөн ажлын үр дүн, хариуцлага, ёс зүй, харилцаа хандлага, гэр бүлийн байдалд нь шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлдэг талаар цагдаагийн албан хаагчдын олонх нь дурдсан болно.

**Дүгнэлт, санал**

Монгол Улсад хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн үр дүнд 2017 оны Цагдаагийн албаны тухай хуулийн зохицуулалтаас харахад цагдаагийн байгууллага нь төрийн тусгай алба бөгөөд цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал баталгаагаар хангагдсан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зарлигаар цол олгох журамд заасан хугацааны дагуу тодорхойлсон цэргийн байгууллага болгон тодорхойлжээ. Мөн цагдаагийн байгууллагад дотоодын цэргийн байгууллага байх бөгөөд дотоодын цэрэг болон цагдаагийн байгууллагын чиг үүргийг хуулиар ялган зааглаж зохицуулжээ. Гэсэн хэдий ч цагдаагийн алба хаагч нь цэргийн алба хаагчийн нэгэн адил эрх зүйн байдал, баталгаагаар хангагдаж байгаа бөгөөд хуулийн үзэл баримтлалын хувьд цэргийн байгууллага болох эрх зүйн үндэс бүрджээ. Энэ бүгдээс үзэхэд орон тоо дутмаг учраас цагдаагийн алба хаагчид илүү цагаар ажиллаж байх бөгөөд төсөв хүрэлцээгүйн улмаас илүү цагаар, амралтын болон баярын өдөр ажилласан цалинг олгохгүй байгаа нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой үндсэн эрхийн зөрчил яах аргагүй байгаа юм. Тэгэхдээ тус хуулиар цагдаагийн алба хаагчийн эдийн засаг, хууль зүй, улс төр, нийгмийн баталгааг хангагдахуйц байдлаар тусгаж өгсөн нь ач холбогдолтой авч тухайн хуулийг нэг мөр хэрэгжүүлэх алба хаагчийн эрх зүйн бадалтай холбоотой асуудалд байгууллагын удирдлагаас хуулийг хэрэгжүүлэх тал дээр учир дутагдалтай болох нь судалгаагаар харагдаж байна. Тухайлбал ЦАтХ-ийн 88.4-т *“...Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гамшиг, хорио цээрийн дэглэм сахиулах болон онц байдлын үед үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчийн албан тушаалын цалинг ажилласан цаг тутамд хоёр дахин нэмэгдүүлж олгоно.”*, 90.2.-т *“Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй*

*ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг таван жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална", 87.8-д "Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан, эсхүл албанаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол энэ хуулийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгоно",* 87.4-д *"Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрээр ажилласан нэг жилийг **нэг жил гурван сараар,** цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан нэг **жилийг нэг жил дөрвөн сараар тус тус тооцно"*** гэх мэтчилэнгээр эрх зүйн байдлыг дээрдүүлсэн маш олон зохицуулалт тусгагдсан нь саашаалтай.

Эцэст нь дүгнэхэд тухайн байгууллагын үйл ажиллагаанд боловсон хүчний бодлого маш чухал болох нь өгүүллийн агуулгаар тодорхойлогдож байгаа бөгөөд үүнд албаны үйл ажиллагааны чанар үр дүн нь алба хаагчийн эрх зүйн байдал, ажлын ачаалал, үнэлгээ зэрэгтэй шууд хамааралтай байна. Мөн цагдаагийн албанд орох иргэний сонгон шалгаруулалт, боловсон хүчин бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөр, давтан сургалт, мэргэшүүлэн сургах тасралтгүй процесс, тус албанаас гарсан иргэнд тавих хяналтыг ч мөн орхиж үл болох асуудал байна.

Байгууллагын нэршил, салбарын хууль, төрийн бодлого чиглэл, үзэл баримтлал өөрчлөгдөх тоолонд Цагдаагийн алба хаагчийг бэлтгэдэг сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах нь тухайн байгууллагын Үндсэн хуулиар тодорхойлсон үндсэн чиг үүрэг өөрчлөгдөөгүй өнөөдрийг хүртэл хэвээр хадгалагдаж ирснийг санаж боловсон хүчин бэлтгэх суурь бодлого, сургалтын хөтөлбөрийн үндсэн цөм тогтвортой байх ёстой болов уу.

**Эх сурвалжийн жагсаалт**


- Монгол улсын Үндсэн хууль УБ., 1992 он, Төрийн мэдээлэл №1
- Төрийн албаны тухай хууль УБ., 2018 он, Төрийн мэдээлэл №5
- Монгол улсын Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2017 он, Төрийн мэдээлэл №06
- Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2013, Төрийн мэдээлэл №29
- Монгол улсын Засгийн газар "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив, УБ., 2011 оны 153 дугаар тогтоол
- Монгол улсын Засгийн газар "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр" УБ., 2020 он, 141-р тогтоол
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.3 Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн тоггоол, УБ., 2015, №2 https://legalinfo.mn/mn/detail?lawId=10916
- Улсын дээд шүүхийн тайлбар, УБ., 2006, №8
- Эрүүгийн эрх зүй дэхь судалгааны илтгэл, Франц улс, Страсбург хот 2009 он, Щвецарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Иргэдийн Алъянс Төвийн орчуулга, ХЗҮХ-ээс 2009, 2009 онуудад явуулсан "Эрүүгийн

байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгааны дүнhtt://www. icac.nsw.gov.au/files/pdf/pub2_5q1.

- Хууль зүйн англи хэлний толь Black's Dictionary

- Тэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл-II, УБ., 2013 он

- ХЭҮК-оос “МУ дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 14 дэх илтгэл” УБ., 2015 он тайлан илтгэл.